



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/04/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhand@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Ugtakhbayar@audit.gov.mn Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Doljinsurend@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. Аудитын илрүүлэлт	7
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.08.25

№

85

танай

-ны №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГУРВАНСАЙХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Б.ЭНХТУЯА
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэнтэй холбоотой төсөвт байгууллагуудын цалингийн зардал өмнөх оноос 107.1 сая төгрөгөөр өссөн байна.

Гурвансайхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны орон нутгийн төсөв багтах тухай 21 дугаар тогтоолоор 1,960,985.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,009,695.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 102.5 хувиар биелүүлж, 48,710.8 мянган төгрөгөөр орлого давсан байна.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад 2025 оны сүүлээр төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн сангийн дансны гүйлгээний

4826050285

эрхийг хаасантай холбоотой төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны зардалтай холбоотой өр төлбөр өсч, өмнөх оноос 25.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 89 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 87 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 94.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,973,079.1	3,604,953.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,237,529.4	3,114,954.7
33	АВЛАГА	518,668.9	131,528.3
35	БАРАА МАТЕРИАЛ	180,980.9	218,282.9
36	НӨӨЦИЙН БАРАА	-	140,187.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	35,900.0	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,783,247.8	6,421,511.9
39200	Биет хөрөнгө	5,710,604.5	6,357,889.9
39300	Биет бус хөрөнгө	72,643.3	63,621.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,756,327.0	10,026,465.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,342,109.2	2,367,055.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	82,119.2	107,065.6
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,259,990.0	2,259,990.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,414,217.7	7,659,409.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,756,327.0	10,026,465.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,877,547.2	3,578,300.2
11	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,530,727.8	1,979,061.7
110	1.1.1.03.1 Орлогын албан татвар	1,235,420.6	1,415,299.4
1100	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	1,235,420.6	1,415,299.4
113	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	144,112.7	368,352.9
118	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	151,194.5	195,409.4
1180	1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	22,525.1	26,364.2
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	717,783.0	1,599,238.5
122	1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	77,619.4
13	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,629,036.4	-
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,048,581.7	2,265,492.5
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,048,581.7	2,265,492.5
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,986,574.6	2,094,951.5
2101	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	611,650.8	725,898.2
2102	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,418.0	84,149.0
2103	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	393,573.2	385,798.4
2104	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	71,938.6	56,922.9
2105	1.1.2.01.1.05 Нормативт зардал	6,986.9	-
2106	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	24,487.2	65,345.3
2107	1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	23,062.0	25,060.0
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,305.7	107,683.4
213	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,007.0	170,541.0
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,828,965.5	1,312,807.8
V	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	487,018.6	67,827.3
VII	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(487,018.6)	(67,827.3)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,341,946.9	1,244,980.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,104,278.5	5,104,278.5
1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(32,007.7)	(32,007.7)
1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,072,270.8	5,072,270.8
1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	8.7	8.7
1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(8.7)	(8.7)
1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	1,341,946.9	1,341,946.9
1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,414,217.7	6,414,217.7
1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,414,217.7	6,414,217.7
1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	692.9	692.9
1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,414,910.6	6,414,910.6
1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(481.4)	(481.4)
1.7 Тайлант үеийн үр дүн	1,244,980.5	1,244,980.5
1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,659,409.7	7,659,409.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,299,746.8	3,540,063.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,530,727.8	1,979,061.7
110	Орлогын албан татвар	1,235,420.6	1,415,299.4
113	Хөрөнгийн албан татвар	144,112.7	368,352.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	151,194.5	195,409.4
1181	Газрын төлбөр	128,669.4	169,045.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142,744.4	1,561,002.2
120	Нийтлэг татварын бус орлого	142,744.4	151,084.7
122	Тусламжийн орлого	-	95,050.7
1221	Хандив тусламж /дотоод/	-	95,050.7
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,314,866.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,626,274.6	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,466,890.3	1,752,567.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,466,890.3	1,752,567.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,404,883.2	1,569,590.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	613,300.8	725,998.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,418.0	84,149.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	401,413.7	418,740.3
2104	Хангамж, бараа материалын зардал	36,755.0	30,354.0
2105	Нормативт зардал	1,905.0	6,448.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,859.2	60,625.6
2107	Томилот, зочны зардал	23,062.0	15,740.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,308.7	106,623.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	192,860.9	120,911.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,007.0	182,976.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,832,856.5	1,787,496.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	467,166.2	910,071.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	467,166.2	910,071.3
2200	Дотоод эх үүсвэрээр	467,166.2	910,071.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(467,166.2)	(910,071.3)
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,365,690.4	877,425.3
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	871,839.1	2,237,529.4
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,237,529.4	3,114,954.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,338,493.1	3,373,897.6
11	Татварын орлого	1,943,985.0	1,979,061.7
12	Татварын бус орлого	3,394,508.1	1,394,835.9
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,588,493.1	2,495,072.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,267,640.8	1,587,681.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,085,369.4	1,488,255.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	871,266.1	725,998.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,385.1	84,149.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	427,173.4	406,154.7
2104	Хангамж, бараа материалын зардал	41,737.5	28,702.0
2105	Нормативт зардал	1,027.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,253.0	35,111.0
2107	Томилолт, зочны зардал	17,520.0	15,740.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	181,613.6	77,622.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	367,393.7	114,778.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	182,271.4	99,425.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	111,155.8	99,425.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,170,970.1	907,391.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	149,882.2	-
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,237,529.4
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,116,354.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Дансны нэр	Дүн
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	95,050.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,050.7
122	Тусламжийн орлого	95,050.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,050.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,615.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,615.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,585.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,652.0
2105	Нормативт зардал	6,448.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,714.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,480.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,733.5
6	Урсгал шилжүүлэг	12,435.7

3. Аудитын илрүүлэлт

3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Гурвансайхан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 5,984.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 4,319.1 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,664.9 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 4,319.1 мянган төгрөгийн 1 алдаа¹ илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

- Мал хамгаалах сангийн мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн хөрөнгийн орлогыг 4,319.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;

Залруулаагүй алдаа:

Аудитаар нийт 203,701.6 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

3.1.1 Албан шаардлага

3.1.1.1 Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь өндөр насжилттай 868.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*); мөн хуулийн 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*) Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д (*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*), Төсвийн тухай хуулийн 6.4.8-д (*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*), 16.5.2-д (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*) заасныг;

3.1.1.2 Мал хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь өндөр насжилттай 797.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), мөн хуулийн 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*) Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д (*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*), Төсвийн тухай хуулийн 6.4.8-д (*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*), 16.5.2-д (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*) заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудита	Д	
		Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт дүнгээр 443,503.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,678.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,639.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 201,797.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага, 231,447.2 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 98 хувийг залруулагдаагүй, 2 хувийг залруулсан алдаа эзэлж байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй 434,825.2 мянган төгрөгийн зөрчлийн 53.9 хувь буюу 234,362.7 мянган төгрөгийн нийцлийн асуудал, 46.1 хувь буюу 200,462.4 мянган төгрөг нь санхүүгийн аудитын асуудал байна.

Аудитын дүгнэлтэд нөлөөлөх санхүүгийн асуудлын 84.2 хувь буюу 168,822.9 мянган төгрөгийн зөрчил нь завсрын аудитаар илэрсэн зөрчил бөгөөд жилийн эцсийн аудитаар зөрчлийг арилгасан байна. Үүнээс санхүүгийн асуудлын хэрэгжээгүй 31,639.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 4,143.5 мянган төгрөгөөр бага байна.

Иймд Гурвансайхан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	3,740.0			1	3,740.0	1	3,740.0				
ИТХ	1	10.0			1	10.0	1	10.0				
МХС	1	4,319.1	1	4,319.1			1	4,319.1				
ХХС	2	609.2			2	609.2	2	609.2				
Дүн	5	8,678.3	1	4,319.1	4	4,359.2	5	8,678.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	3	170,462.5	2	1,639.6	1	168,822.9						
ОНХС	2	30,000.0			2	30,000.0						
Нийт дүн	5	200,462.5	2	1,639.6	3	198,822.9					-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ЗДТГ	1	1,250.0			1	1,250.00						
ОНХС	2	231,447.8					2	231,447.8				
МХС	1	868.0			1	868.0						
БХС	1	797.0			1	797.0						
Нийт дүн	5	234,362.8			3	2,915.0	2	231,447.8				